


Отрын малчид цаашид яах вэ?

Бэлтгэсэн Цөлжилтийн судалгааны салбарын ЭШДЭА Б. БЯМБАСҮРЭН




Эрт үеэс уламжлан ирсэн бэлчээрийн мал аж ахуй нь дэлхийн бусад улс орнуудаас ялгарах бидний түүхэн ёс заншил билээ. Хэдийгээр өнөөдөр уламжлалт нүүдлийн мал аж ахуй, суурин амьдралын хэв маяг гэсэн хоёр өөр хэв шинжтэй болж байгаа ч эртний түүхт нүүдэлчин монголчууд бид дөрвөн улирлын аясаар мал аж ахуйгаа эрхэлж, өв уламжлалаа хадгалж байгаа малчин түмнийг хүндэтгэх учиртай билээ.

Манай орны хувьд 2000 оноос хойш малын толгой эрчимтэйгээр өссөөр байна. Жишээ нь 2001-2019 оны байдлаар бэлчээрийн талбай 126.6-112.0 сая га болж 14.6 сая га-гаар багасаж, нийт малын тоо 26,1 -70,9 сая толгой буюу 2,7 дахин өссөн байна. Ийнхүү малын тоо толгой эрчимтэйгээр өсөж байгаа нь бэлчээрийн даац хэтэрч улмаар газрын доройтолд хүргэх бас нэгэн шалтгаан болж байна. Бэлчээр ашиглалтын эрчим өндөр байх нь ургамал ургалт болон хөрсний физик, хими, биологийн чанарт сөргөөр нөлөөлдөг. Малын хөлд байнга талхлагдан, жим үүссэн хөрсний өнгөн хэсэг нунтгаран бүтцээ алдах, шинж чанар доройтох нь түгээмэл ажиглагддаг. Хашаалаагүй бэлчээр нь малын хөлөөр машин механизмынх шиг тодорхой мөрөөр дагтаршихгүй ч, нөлөө нь талбайд жигд тархана. Малын хөлийн улмаас хөрсний эзлэхүүн жин нэмэгдэн, ус шингээлтийн зэрэг, ус дамжуулалт, агаар солилцоо буурч, ус чийгийн баланс алдагддаг. Манай орны хувьд нэн түрүүнд бэлчээрт халтай ямаан сүргийн тоо толгойг хязгаарлах явдал юм. Бог малын хувьд өсгөж үржүүлж ирсэн уламжлалт харьцаа 75:25 хувь буюу 3 хонь, 1 ямаа байсан бол одоогийн байдлаар бог малын 47,6 хувийг ямаа 52,4 хувийг хонь эзэлж байна.



Тахирмаг 1. Малын тоо толгойн өсөлт бүх сүргээр 1980-2019 он




Тахирмаг 2. Малын тоо толгойн өсөлт сүрэг тус бүрээр 1980-2019



Мөн байгаль цаг уурын нөхцөл байдлаас хамаарч зарим бүс нутагт хур тунадас багаар орж байгаатай холбогдуулан малчид отор нүүдэл ихээр хийж байна. Монгол улсын засгийн газраас мал сүргийг байгалийн болон гэнэтийн давагдашгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор 15 аймгийн газар нутгийг хамарсан 783.3 мян.га газрыг улсын тусгай хэрэгцээнд

авч 9 аймаг дундын отрын бүс нутгийг байгуулсан. Өнөөдрийн байдлаар Архангай, Булган, Дундговь, Өвөрхангай, Төв аймгийн 3.2 сая мал Архангай, Булган, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Төв аймагт отор нүүдэл хийж байна. Зуншлага муу, гантай байсан аймгуудын малыг улсын тусгай хэрэгцээний аймаг дундын Чилэн, Хөх дэл, Малах, Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт оруулжээ. 2007 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн Дугаар 187 тогтоолоор Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Төв аймгийн Баянжаргалан, Хэнтий аймгийн Дархан сумын хилийн заагт орших Малахын талын 73.1 мянган га, газрыг аймаг дундын отрын бүс нутаг болгосон бөгөөд. Тус бүс нутагт жилд дунджаар 30-40 мянган мал өвөлж байсан бол энэ оны урьдчилан авсан захиалгаар өвөлжихөөр талын отрын бүс 634502 мал өвөлжихөөр болсон ба нийт өвөлжиж буй малыг бог малд буюу хонин толгойд шилжүүлэхээр 1047893 болж байгаа (1 тэмээ-5 хонь 1 адуу - 7 хонь 1 үхэр - 6 хонь 1 хонь - 1 хонь 1 ямаа - 0.9 хонь) бөгөөд 100 га ноогдох бог малын тоог хэдэн дахин хэтрүүлж байгаа нь ажиглагдаж байна. Иймд отрын бүс нутгууд бэлчээрийн даац хэтэрч улмаар газрын доройтолд орж ургамлын нөмрөг багасах үед отрын малчид цаашид яах вэ?



Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэнд 2020 оны 8 дугаар сарын 26-нд боловсруулсан бэлчээрийн даацын зураг

